

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



ЖИЛИЙН ТАЙЛАН

2020

www.mse.mn



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE





АГУУЛГА

| | |
|-------------------------------------|----|
| Гүйцэтгэх захиралын мэндчилгээ | 1 |
| Бидний тухай | 2 |
| 2020 оны санхүүгийн гол үзүүлэлтүүд | 8 |
| Компанийн засаглал | 10 |
| Оны онцлох үйл явдлууд | 13 |
| Хөрөнгийн зах зээлийн тойм | 22 |
| Аудитын тайлан | 32 |

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Монгол улсад хөрөнгийн зах зээл үүсч, Монголын хөрөнгийн бирж байгуулагдсанаас хойш эдүгээ 30 жилийг туулан өнгөрүүлжээ. Өнгөрсөн хугацаанд Монголын хөрөнгийн зах зээлийн техник технологи, хууль эрх зүйн орчин олон улсын жишгийн дагуу шинэчлэгдэж, манай зах зээл хөгжлийн шинэ шатанд гарсан билээ.

Сүүлийн жилүүдэд манай хөрөнгийн зах зээлд хувьцаа бондын арилжаа идэвхжиж, шинээр болон нэмж үнэт цаас гаргах зэрэг олон үйл ажиллагаа амжилттай явагдаж байгаагийн зэрэгцээ онцлог шинэ үйл явдлуудаар өрнүүн байна. Тухайлбал, 2017-2020 онуудад МХБ дээр түүхэн дээд хэмжээний хувьцаа, ЗГҮЦ-ны арилжаа хийгдсэн, хамгийн олон IPO бүртгэгдсэн, үүнд үнэт цаасны анхны давхар бүртгэл, даатгалын компанийн үнэт цаас бүртгэгдсэн, давхар бүртгэлтэй үнэт цаас гадаадын бирж болон МХБ хооронд хөрвөн арилжигдах боломжтой болсон, манай бирж дээр урьд өмнө арилжигдаж байгаагүй цоо шинэ бүтээгдэхүүнүүд болох хамтын хөрөнгө оруулалтын сан, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нэвтэрсэн зэрэг ололт амжилттай байна.

МХБ нь зах зээлийн энэхүү таатай орчин нөхцөлд тулгуурлан хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор МХБ дээр арилжигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлэх, зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэхэд зах зээлийн зохицуулагч болон мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна.

Монголын хөрөнгийн зах зээлд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, өмнөх зорилтуудаа амжилттай хэрэгжүүлэхэд бидний хамтын ажиллагаа бодит үр дүнд хүрнэ гэдэгт итгэлтэй байгаа бөгөөд хамтран ажилладаг зах зээлийн оролцогчид, үнэт цаас гаргагчид болон хөрөнгө оруулагчид та бүхэнд өндөр амжилт хүсье.

Хөрөнгийн зах зээл цаашид улам хөгжин дэвшиж, хөгжлийн гарц байх болтугай!



Х. АЛТАЙ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БИДНИЙ ТУХАЙ

Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн түүхэн үе шатанд улсын эдийн засгийн нийт бүтцийг өөрчлөх, зах зээлийн өрсөлдөөнийг бий болгох, эдийн засагт хувийн секторыг дэмжин хөгжүүлэх, улмаар эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг биелүүлэхийн тулд өмч хувьчлалыг аль болох богино хугацаанд өргөн хүрээтэйгээр явуулан цаашид эдийн засаг дахь хөрөнгийн урсгалыг хамгийн үр ашигтай хэлбэрээр зохицуулах зорилгоор Монголын хөрөнгийн биржийг /МХБ/ үүсгэн байгуулсан. Энэхүү түүхэн үед МХБ-ээр 475 улсын үйлдвэрийн газрын хувьцааг цэнхэр, ягаан тасалбараар 1.2 сая иргэнд эзэмшүүлж хувьчилснаар Монгол Улсад орчин үеийн зах зээлийн эдийн засгийн үндэс суурь тавигдаж байсан.

МХБ нь энэхүү түүхэн үүргээ амжилттай гүйцэтгэхийн сацуу өнөөг хүртэл 40 гаруй аж ахуйн нэгжид 187.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэхэд зуучлан, нийт 3.3 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасны арилжаа зохион байгуулаад байна.

| 2019 он | 2020 он | |
|-----------------|-----------------|--------------------------|
| ₮2,690.3 тэрбум | ₮3,026.5 тэрбум | Зах зээлийн үнэлгээ |
| 19,621.86 | 19,285.80 | ТОП-20 индекс |
| 198 | 192 | Бүртгэлтэй компанийн тоо |
| ₮570 сая | ₮263 сая | Өдрийн дундаж арилжаа |

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу МХБ нь олон улсад нэр хүнд бүхий Лондонгийн хөрөнгийн бирж групптэй стратегийн түвшинд хамтран ажиллаж, хөрөнгийн зах зээлийн зохицуулалт, техник, технологи, дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлсэн билээ.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг 2013 онд шинэчлэн найруулахад МХБ-ийн зүгээс чухал үүрэгтэйгээр оролцож, үнэт цаасны зах зээлийн хууль эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилсний үр дүнд гадаад улсын компанийн үнэт цаасны давхар бүртгэл, хадгаламжийн бичиг, төлбөр тооцооны дараа төлбөрт систем, үнэт цаасны номиналь болон бенефициар өмчлөл, кастодианы үйлчилгээ зэрэг олон шинэ концепциуд зах зээлд шинээр нэвтэрсэн юм. Ингэснээр 2018 онд гадаад улсын компанийн үнэт цаасыг анх удаа МХБ дээр давхар бүртгэж арилжаалсан, арилжааны үнийн дүн хамгийн дээд хэмжээндээ хүрсэн, 2019 онд анхдагч зах зээлээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн дээд амжилтаа тогтоосон зэргээр хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд урьд өмнө байгаагүйгээр идэвхжиж, чамлахааргүй их амжилтанд хүрч байна.

Түүнчлэн, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хөрөнгийн биржээр арилжаалах зохицуулалтыг цоо шинээр бүрдүүлж, хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилтийг сайжруулж хариуцлагажуулах, төлбөр тооцооны дараа төлбөрт T+2 горимыг амжилттай нэвтрүүллээ.



1991 он



2020 он

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ТҮҮХЭН ТОВЧООН

| | | |
|--|--|--|
| Монголын Хөрөнгийн Бирж байгуулагдав | Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа эхлэв. | Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдав. |
| 1991.01.18 | 1992.02.07 | 1994.09.26 |
| Үнэт Цаасны Хороо байгуулагдав | Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо байгуулагдав. | Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэв. |
| 1994.11.14 | 1995.07.08 | 1995.08.28 |
| ТОР-75 индекс тооцож эхлэв. | Засгийн газрын бондыг хөрөнгийн биржээр арилжаалж эхлэв. | ТОР-20 индекс тооцож эхлэв. |
| 1995.08.28 | 1996.10.25 | 2001.02.09 |
| Анхны компанийн бондыг арилжаалав. | Анхны IPO амжилттай хийгдэв. | Лондонгийн хөрөнгийн бирж групптэй стратегийн түншлэлийн “Ажлын мастер гэрээ” байгуулав. |
| 2001.06.08 | 2005.05.25 | 2011.04.07 |
| Олон улсад нэр хүнд бүхий “Миллениум Ай Ти” цогц системийг зах зээлд нэвтрүүлэв. | Монголын хөрөнгийн бирж өөрийгөө зохицуулах байгууллага болов. | Төрийн өмчийн хувьчлалыг хөрөнгийн биржээр нээлттэй явуулав. |
| 2012.07.02 | 2014.12.02 | 2015.12.22 |
| 859.2 тэрбум төгрөгийн арилжаа хийж, түүхэн дээд амжилт тогтоов. | MSE A болон MSE B индексүүдийг тооцож эхлэв. | Анхны гадаадын үнэт цаасыг давхар бүртгэв. |
| 2017 | 2018.02.08 | 2018.04.04 |
| Төлбөр тооцооны T+2 горимд шилжив. | Анхны хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан бүртгэгдэв. | Анхны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэв. |
| 2020.03.31 | 2020.08.24 | 2020.12.28 |



ГАЗРУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

Захиргаа, санхүүгийн газар нь компанийн дотоод зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж ажиллах ба чиг үүргээрээ Захиргааны алба, Санхүүгийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Үйл ажиллагааны газар нь арилжааны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах, хөрөнгийн биржийн мэдээллийн технологийн дэд бүтцийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих үндсэн чиг үүрэгтэйгээр Зах зээлийн хөгжлийн алба, Арилжааны алба, Мэдээллийн технологийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Хяналт, зохицуулалтын газар нь бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой үнэт цаас гаргагч байгууллагууд, гишүүн үнэт цаасны компани, арилжааны хяналт, хөрөнгийн зах зээлийн эрсдэлийн үнэлгээ хийх чиг үүрэгтэйгээр Хяналт шинжилгээний алба, Бүртгэлийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж байна.




Гүйцэтгэх захирал
Х. Алтай

*Хуульч
Бизнесийн удирдлагын магистр*

МХБ-ийн гүйцэтгэх захирлын үүрэг хариуцлагын талаар Компанийн дүрэмд тодорхой заасан байдаг. Гүйцэтгэх захирал нь МХБ-ийн өдөр тутмын удирдлага, үйл ажиллагааг хариуцаж, ТУЗ-өөс баталсан үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

УДИРДЛАГЫН БАГИЙН ГИШҮҮД



Захиргаа, санхүүгийн газрын захирал
Н. Дөл-Эрдэнэ

*Санхүүч-эдийн засагч
Бизнесийн удирдлагын магистр
Олон улсын бизнесийн удирдлагын докторант*

Хяналт, зохицуулалтын газрын захирал
А. Мөнхбаясгалан

*Эдийн засагч
Төрийн удирдлагын магистр*



Үйл ажиллагааны газрын захирал
И. Жавхлан

*Санхүүч
Санхүүгийн удирдлагын магистр*

ХҮНИЙ НӨӨЦ

МХБ-ийн “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг орчин үеийн хүний нөөцийн удирдлагын чиг хандлага, байгууллагын ажилтнуудын зан төлөвт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аливаа байгууллагын үндсэн үүргийн хувиар ажилтнуудын боловсрол, мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх сургалт зохион байгуулж, мөн нэмэлт ур чадварыг бий болгох чиглэлийг дэмжин ажиллав.

Хүний нөөцийн хөдөлгөөн, хуваарилалтыг амжилттай хэрэгжүүлснээр 2020 оны эцэст нийт 52 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаа ба урт хугацааны чөлөөтэй 8 ажилтан байна.



52

Нийт ажилтан



29

Нийт эмэгтэй ажилтан



23

Нийт эрэгтэй ажилтан



27

Үндсэн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн



19

Захиргаа, аж ахуйн ажилтан



39

Дундаж нас



8 ЖИЛ

Ажилласан дундаж хугацаа



6

Удаагийн сургалт



44

Дээд боловсрол

Үүнээс:



20

Магистр



24

Бакалавр



2

Мэргэшсэн нягтлан бодогч



1

Олон улсын итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч

3

Олон улсын итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч цол горилогч




Олон улсын мэргэшсэн компьютерийн сүлжээний инженер


1

СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Нийт орлого, сая ₮




Нийт зардал, сая ₮




Арилжааны шимтгэл, сая ₮




МІТ системийн ашиглалт, үйлчилгээний төлбөр, сая ₮



Төсөвт төлсөн татвар, шимтгэл, сая ₮



Цэвэр ашиг, сая ₮



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



Компанийн засаглал

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь компанийн хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэгч Сангийн яам буюу Сангийн сайдын тушаалаар томилогддог бөгөөд 6 хараат болон 3 хараат бус гишүүдийн бүрэлдэхүүнтэй.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн бүтэц, зохион байгуулалтыг 2017 онд нийт 3 газар, 6 албадын бүрэлдэхүүнтэй буюу нийт 52 ажилтны орон тоотойгоор өөрчлөн баталсан бөгөөд 2019 онд ГЗ-ын А-34 дугаар тушаалаар ҮАГ-ын ЗЗХ-ийн албанд судалгаа хариуцсан мэргэжилтэн, ХЗГ-ын БА-нд Үнэлгээ, эрсдэл хариуцсан мэргэжилтний тоог тус тус нэгээр нэмэгдүүлснээр нийт орон тоо 54 болсон. Хүний нөөцийн хөдөлгөөн, хуваарилалтыг амжилттай хэрэгжүүлснээр 2020 оны эцэст 51 үндсэн болон 3 гэрээт ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаа ба урт хугацааны чөлөөтэй 4 ажилтан байна

ТУЗ-ийн үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөл нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, компанийн дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомж, “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын дагуу үйл ажиллагаа явуулдаг.

ТУЗ-ийн хороод

МХБ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 3 хороотой байх бөгөөд хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал, дүгнэлт гаргах үндсэн зорилготой. ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хууль болон “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-аар ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг зохицуулна. ТУЗ нь дараах байнгын хороодтой:

Аудитын хорооны бүрэлдэхүүн

| | Нэр | Үүрэг |
|---|------------|--------|
| 1 | А.Батпүрэв | Дарга |
| 2 | Б.Сүх-Очир | Гишүүн |
| 3 | А.Анар | Гишүүн |

ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг.

Цалин урамшуулалын хороо

| | Нэр | Үүрэг |
|---|-------------|--------|
| 1 | Д.Баянзул | Дарга |
| 2 | Р.Гандиймаа | Гишүүн |
| 3 | А.Анар | Гишүүн |

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ) нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2 дахь заалт, Компанийн Дүрмийн 7.2-т заасны дагуу 2020 онд 6 хараат, 3 хараат бус, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаа. Тайлант хугацаанд ТУЗ нийт 6 удаагийн хуралдаанаар 33 асуудал хэлэлцэж, компанийн үйл ажиллагаа болон ТУЗ-ийн дотоод ажилтай холбоотой 18 тогтоол баталж, 5 тэмдэглэлээр гүйцэтгэх удирдлагад үүрэг, даалгавар өгч ажилласан.

Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн

| | Нэр | Үүрэг |
|---|-------------|--------|
| 1 | Л.Сонор | Дарга |
| 2 | Р.Гандиймаа | Гишүүн |
| 3 | А.Батпүрэв | Гишүүн |

Цалин, урамшуулал

ТУЗ-ийн гишүүдэд сар бүр тогтмол урамшуулал олгодог. ТУЗ-ийн гишүүний цалин хөлсний хэмжээг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын дагуу тогтоодог бөгөөд гишүүдийн цалин хөлсний дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байдаг.

ТУЗ-ийн гишүүдийн бие даасан байдал

МХБ-ийн ТУЗ нь Компанийн тухай хуулийн 75.4 заалтын дагуу хараат бус 3 гишүүнтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны гишүүний танилцуулга, холбогдох баримт материалыг “Авилгатай тэмцэх газарт” /АТГ/-т хүргүүлэн бие даасан байдлыг тодорхойлуулдаг. АТГ нь гишүүд, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн төлөө ажиллахад, бие даасан үйл ажиллагаа явуулахад материаллагаар нөлөөлж болох ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг хянаж шалгадаг.

“МХБ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНД АЖИЛЛАСАН БҮРЭЛДЭХҮҮН

| | Нэр | Үүрэг | Албан тушаал | Томилогдсон огноо |
|---|--------------|--------------------------------|--|-------------------|
| 1 | М.Батхуяг | ТУЗ-ийн дарга Хараат гишүүн | Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга | 2018/03/26 |
| 2 | Б.Ганбат | Хараат гишүүн | Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга | 2019/07/23 |
| 3 | Б.Сүх-Очир | Хараат гишүүн | Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга | 2018/03/26 |
| 4 | Л.Сонор | Хараат гишүүн | Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга | 2018/03/26 |
| 5 | М.Санжаадорж | Хараат гишүүн | Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга | 2019/07/23 |
| 6 | Д.Баянзул | Хараат гишүүн | Монголбанкны Эрсдэлийн удирдлагын албаны захирал | 2018/03/26 |
| 7 | Р.Гандиймаа | Хараат бус гишүүн | МҮОНРТ-ийн “Монголын мэдээ” сувгийн захирал | 2018/07/04 |
| 8 | А.Батпүрэв | Хараат бус гишүүн | “Скайтел групп” ХХК-ийн Стратеги, удирдлагын захирал | 2018/07/04 |
| 9 | А.Анар | Хараат бус гишүүн | “МИК ОССК” ХХК-ийн Үйл ажиллагааны газрын захирал | 2018/07/04 |

ТУЗ-ийн бүрэлдэхүүнд 2020 онд өөрчлөлт ороогүй. ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг ахин томилсон.

ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



ТӨЛБӨРИЙН ЭСРЭГ НИЙЛҮҮЛЭЛТ ЗАРЧИМД СУУРИЛСАН ҮНЭТ ЦААСНЫ ДАРАА ТӨЛБӨР ТООЦООНЫ Т+2 ГОРИМЫГ 2020 ОНЫ 3 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР НЭВТРҮҮЛЛЭЭ

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчимд суурилсан Үнэт цаасны дараа төлбөр тооцооны Т+2 горимыг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс нэвтрүүлэв.

Энэхүү шинээр нэвтэрч буй төлбөр тооцооны горимоор арилжаанд оролцоход хөрөнгө оруулагчид эрсдэлийн түвшингээсээ хамаарч 100 хувь мөнгөн хөрөнгө байршуулалгүй тодорхой хувийг нь урьдчилан байршуулж захиалга өгөх бөгөөд 2 хоногийн дотор үлдсэн мөнгөө байршуулж, төлбөр тооцоог гүйцэтгэх боломжтой боллоо. Ингэхдээ “Арилжааны төлбөр тооцоо” ХХК-ийн гишүүнчлэлд хамрагдсан клирингийн гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан арилжаанд оролцсоноор ийнхүү төлбөр тооцоог гүйцэтгэх боломжтой.

“Арилжааны төлбөр тооцоо” ХХК-ийн гишүүнчлэлд хамрагдаагүй үнэт цаасны компаниудаар дамжуулан үнэт цаасны арилжаанд оролцох хөрөнгө оруулагчдын хувьд одоогийн төлбөрийн нөхцөлөөр буюу урьдчилан эх үүсвэрийг байршуулснаар арилжаанд хэвийн оролцох бөгөөд харин үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог Т+2 горимын дагуу 2 хоногийн дараа гүйцэтгэнэ.

Үнэт цаасны дараа төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчим нэвтэрснээр зах зээлд оролцогчдын арилжааны шимтгэл, зардал буурч, зах зээлийн хөрвөх чадвар сайжрах, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид үнэт цаасны арилжаанд оролцоход таатай нөхцөл бүрдэх зэрэг эерэг нөлөөтэй юм.

"АРИЛЖААНЫ ЖУРАМ"-Д НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРЛОО



"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар 07-ны өдрийн 2020/07 тоот тогтоолоор баталсан "Арилжааны журам"-ын нэмэлт өөрчлөлтийг СЗХ-ны даргын 2020 оны 3-р сарын 19-ны 123 тоот тушаалаар батламжилсан байна.

Уг нэмэлт өөрчлөлтөөр МХБ-ийн арилжааны хэлцэл баталгаажуулах, хэлцэл цуцлах зэрэг нарийвчилсан зохицуулалтуудыг тусгаснаас гадна хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, сангийн нэгж эрх зэргийг арилжих, тэдгээрийн арилжааны шимтгэл хураамжийн талаар нэмж орууллаа.

"БОДЬ ДААТГАЛ" ХК НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2020 оны анхны IPO болох “Бодь Даатгал” ХК нь нийт хувьцааныхаа 20% буюу 47,063,944 сая ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс 6 дугаар сарын 08-ны өдөр авлаа.



“Бодь Даатгал” ХК-ийн нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн нийт захиалгыг ҮЦТХТ дахь мөнгөний үлдэгдэлтэй нийцүүлэхэд 959 хувь хүн, аж ахуйн нэгжийн нийт 5,318,225,672 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн юм.

“Бодь Даатгал” ХК нь шинээр гаргасан 47,063,944 ширхэг үнэт цаасыг МХБ-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын тогтоосон үнийн аргыг ашиглан стратегийн хөрөнгө оруулагчдад 113 төгрөгөөр, олон нийтэд захиалга бүртгэлийн аргаар буюу 113-135 төгрөгийн хооронд санал болгосон бөгөөд захиалгад ирүүлсэн үнэ болон татан төвлөрүүлэх үнийн дүнг харгалзан нэгж хувьцааны үнийг 113 төгрөгөөр тогтоов. Ийнхүү, нийт 15н даатгалын компаниудаас МХБ-д бүртгэлтэй даатгалын компанийн тоо 4-д хүрэв.

"ЛЭНДМН БОНД" МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖЭЭР АМЖИЛТТАЙ АРИЛЖИГДЛАА



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 1-р ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч компани болох “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаагаар баталгаажсан 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нэг жилийн хугацаатай, жилийн 17.0 хувийн хүүтэй өрийн хэрэгсэл “ЛэндМН Бонд” нь 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс 2020 оны 6 дугаар сарын 19-ний өдөр хүртэл Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэйгээр арилжаалагдаж, нийт 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлээ.

Тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд нийт 528 иргэн, аж ахуйн нэгж оролцож, нийт 67,424 ширхэг буюу 6,742,400,000 төгрөгийн үнийн дүн бүхий нийт 541 худалдан авах захиалга ирүүлсэн нь үнэт цаас гаргагчийн санал болгосон хэмжээнээс 34.8%-аар давсан дүн юм.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн захиалгын хуваарилалтын төлөвлөгөөний дагуу 28.8 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй захиалгыг 100 хувь биелүүлж, түүнээс дээш давсан дүнтэй захиалгад үнэт цаасыг 58.8 хувиар хувь тэнцүүлэн хуваарилав.



АНХНЫ ХАМТЫН ХААЛТТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХ БҮРТГЭГДЛЭЭ



МЕНЕЖМЕНТ
КОМПАНИ

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 340 тоот тогтоол болон холбогдох дүрэм, журмыг үндэслэн гаргасан "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн А/56 тоот тушаалаар "Ард менежмент ҮЦК" ХХК-ийн үүсгэн байгуулсан "Үндэсний хувьчлалын сан" хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50,000,000 ширхэг нэгж эрхийг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлсэн нь МХБ-д бүртгүүлсэн анхны хамтын хөрөнгө оруулалтын сан боллоо.

Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС (MSE:ХОС) нь нийт нэгж эрхийнхээ 95 хувь буюу 47.5 сая ширхгийг тус бүрийг нь 100 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаж, нийт 4.75 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн бөгөөд 2,245 хувь хүн, аж ахуйн нэгжийн нийт 5,537,565,300 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь татан төвлөрүүлэх дүнгээс 16.5 хувиар давсан үзүүлэлт боллоо.





АНХНЫ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС БАТЛАГДАН МӨН БҮРТГЭГДЛЭЭ

ИНВЕСКОР АКТИВ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн 2020/06 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 146 тоот тушаалаар батламжиллаа.

Олон улсын жишигт банк, санхүүгийн байгууллагууд активаа багцлан үнэт цаасжуулж, хөрөнгийн зах зээлд худалдан санхүүжилт татах замаар эрсдэлээ хуваалцах нь түгээмэл байдаг бөгөөд энэ төрлийн үнэт цаас арилжигдаж эхэлснээр банк, санхүүгийн байгууллагуудад хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилтийн шинэ суваг нээгдэх, иргэдэд тогтмол хугацаат хүүгийн орлого бүхий эрсдэл харьцангуй багатай хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүн санал болгох боломж бүрдэх юм.

Үүний дараа эхний хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас тодорсон юм. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 938 дугаар тогтоол, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/75 тоот тушаалаар "Инвескор актив ТЗК" ХХК-ийн гаргаж буй доорх нөхцөлтэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэлээ.

Ийнхүү, Монголын хөрөнгийн хөрөнгийн зах зээлд дахин нэгэн шинэ төрлийн бүтээгдэхүүн нэвтэрч, хөрөнгө оруулагчид тогтмол хүү төлдөг, хадгаламжийн дундаж хүүгийн хэмжээнээс өндөр бүтээгдэхүүнд хөрөнгө оруулах боломж нээгдлээ.



ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСИЙГ 20 ХУВИАР ХӨНГӨЛЛӨӨ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө татан төвлөрүүлэх, шинээр үнэт цаас гаргах үйл ажиллагааг дэмжих зорилгоор "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 22 дугаар зүйлийн 22.2.2 дахь заасан үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд 20 хувиар хөнгөллөө.

"БИД ИРЭЭДҮЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД" ТЭМЦЭЭН БОЛЖ ӨНГӨРЛӨӨ

Монгол улсад хөрөнгийн зах зээл үүсч, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан "Бид ирээдүйн хөрөнгө оруулагчид" тэмцээнийг үндэсний томоохон их, дээд сургуулиудтай хамтран амжилттай зохион байгуулагдлаа.

Энэхүү тэмцээний зорилго нь санхүүгийн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудын хөрөнгийн зах зээлийн талаарх онолын мэдлэгээ бататган, цааш гүнзгийрүүлэн судлах нөхцөлийг бүрдүүлэн практик дадлага олж авах, харилцан туршлага солилцож багаар ажиллах чадварыг дээшлүүлэн ирээдүйн мэргэшсэн чадварлаг боловсон хүчин бэлтгэхэд чиглэж байна.

Тэмцээнд оролцогчид хөрөнгө оруулалтын багц үүсгэн арилжаанд бодит мөнгөөр оролцохоороо онцлог бөгөөд МУИС, ШУТИС, СЭЗИС, ХААИС, ХУИС-иудын 5 баг, нийт 25 оюутан мэдлэг ур чадвараа сорин өрсөлдөв.



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК НЬ ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГААР ШАЛГАРЧ, “ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР ШАГНУУЛЛАА

Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газраас төрийн өмчит компаниудтай байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэж, гэрээний хэрэгжилтээр 95%-аас дээш үнэлгээ авсан 27 байгууллагад “ӨРГӨМЖЛӨЛ” гардуулж, тэдгээр байгууллагуудын 31 ажилтан, мэргэжилтнүүдийг “ЖУУХ БИЧИГ”-ээр шагналаа.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлж, төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний үүргээ хангалттай сайн биелүүлж, “Үлгэр жишээ” дүгнэгдсэн тул Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газрын шилдэг байгууллагаар шалгарч, “ӨРГӨМЖЛӨЛ” гардан авлаа.



“ТҮМЭН ШУВУУТ” ХК ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ҮЙЛЧЛЭХ-IR ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ЗАРЛАВ



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аас хөрөнгийн зах зээл үүссэний 30 жилийн ойг тохиолдуулан бүртгэлтэй компаниудын засаглалыг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангуулахаар анхаарч ажиллаа

Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ноос хувьцаат компаниудад хандан гаргасан ил тод, ёс зүйтэй ажиллах уриалгыг дэмжин “Түмэн шувуут” ХК нь “Хөрөнгө оруулагчдад үйлчлэх IR” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа тухай олон нийтэд танилцуулах хэвлэлийн бага хурлыг Монголын хөрөнгийн биржийн байранд зохион байгууллаа. Тус арга хэмжээнд СЗХ-ны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, МХБ-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, “Түмэн шувуут” ХК-ийн ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал О.Болдбаатар нар оролцсон юм.

“Хөрөнгө оруулагчдад үйлчлэх IR” хөтөлбөрийг дэлхийн олон улс орны нээлттэй компаниуд хэрэгжүүлдэг бөгөөд хөрөнгө оруулагчдад компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод, шуурхай хүргэж ажилласнаар хөрөнгө оруулагчидтай бат бэх харилцаа холбоо, итгэлцлийг үүсгэх, урт хугацааны хөрөнгө оруулагчидтай болох, компанийн үнэ цэнийг тогтвортой хадгалах, нэмэлт санхүүжилт татах үйл явцыг хялбаршуулах зэрэг олон талын ач холбогдлыг бий болгодог байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Хувьцааны бүртгэл

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д 2020 оны 12 сарын 31-ний байдлаар 192 ХК бүртгэлтэй байгаагаас 8.8% буюу 17 ХК нь 100 хувь төрийн өмчит, 5.2% буюу 10 ХК нь төрийн өмчийн оролцоотой, 85.9% буюу 165 ХК нь бүрэн хувьчлагдсан компани байна.

Бүртгэлтэй үнэт цаасны хувьд нийт 12.8 тэрбум ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас 31.0% буюу 3.9 тэрбум ширхэг нь төрийн мэдлийн, 69.0% буюу 8.8 тэрбум ширхэг нь хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувьцаа байна.



Бүртгэлтэй компаниудын салбарын ангилал, компанийн тоо

| | | | |
|------------------------------|----|-------------------|----|
| Геологи | 5 | Тээвэр | 10 |
| Уул уурхай | 12 | Нийтийн хангамж | 17 |
| Хүнд үйлдвэрлэл | 4 | Худалдаа | 19 |
| Ойн аж ахуй | 5 | Үйлчилгээ | 9 |
| Хөдөө аж ахуй | 25 | Хэвлэл мэдээлэл | 1 |
| Хүнсний үйлдвэрлэл | 19 | Харилцаа холбоо | 1 |
| Хөнгөн үйлдвэрлэл | 13 | Санхүү | 16 |
| Барилгын материал үйлдвэрлэл | 13 | Үл хөдлөх хөрөнгө | 12 |
| Барилга, зам угсралт | 16 | Технологи | 1 |

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ


Зах зээлийн индикаторууд

2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь арилжигдаж буй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ нь 3 их наяд 026 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 336.2 тэрбум төгрөгөөр буюу 12.5 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ. 12 дугаар сарын 31-ний байдлаар ТОП 20 индекс 19,285.80 нэгж хүрсэн бөгөөд энэ нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 1.71%-аар буурсан үзүүлэлттэй байгаа юм. Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 19,621.9 нэгж, доод үзүүлэлт 15,914.9 нэгж, дундаж үзүүлэлт 17,400.1 нэгж байна.



2020.01.01-2020.12.31

Мөн тайлант хугацаанд MSE A индексийн дээд үзүүлэлт нь 9,531.66 нэгж, доод үзүүлэлт нь 7,447.15 нэгж, дундаж үзүүлэлт 8,320.55 нэгж, харин MSE B индексийн хувьд дээд үзүүлэлт нь 7,950.71 нэгж, доод үзүүлэлт нь 7,223.2 нэгж, дундаж үзүүлэлт нь 7,494.8 нэгж тус тус байна. MSE A индексийн хувьд 2020 оны 3 дугаар сард Ковид-19 халдвартай холбооготоогоор онцгой байдал зарласантай холбогдуулан уналт үзүүлсэн хэдий ч 2020 оны эцэс гэхэд эргэн сэргэсэн үзүүлэлттэй байна.



2020.01.01-2020.12.31

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

ТОП-20 индексийн сагс

Монголын Хөрөнгийн Биржийн "Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай" журмын дагуу үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП-20 индексийн сагсыг жилд 1 удаа шинэчлэн тооцоолдог билээ. Уг журмын дагуу ТОП20 индексийн сагс шинэчлэгдэж, 2020 онд ТОП-20 индексийн сагсыг дараах үнэт цааснууд бүрдүүлэхээр боллоо. 2020 оны үзүүлэлтээр ТОП-20 индексийн сагсыг шинэчлэхэд өмнөх сагсад багтаж байсан 13 компани хэвээр үлдэж, "Гутал" ХК, "Айтүүлс" ХК, "Хай Би Ойл" ХК, "Женко тур бюро" ХК, "Махимпекс" ХК, "Дархан нэхий" ХК, "Талх чихэр" ХК-иуд хасагдаж, шинээр "Ард кредит ББСБ" ХК, "Инвескор ББСБ" ХК, "Монос хүнс" ХК, "Түмэн шувуут" ХК, "Шарын гол" ХК, "Улсын их дэлгүүр" ХК, "Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн" ХК -иуд нэмэгдэн шинэчилсэн сагсыг бүрдүүлж байна.

| № | Симбол | Компанийн нэр |
|----|--------|---|
| 1 | AARD | Ард Санхүүгийн Нэгдэл ХК |
| 2 | ADB | Ард Кредит ББСБ ХК |
